



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 620

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Инженер техник, аж ахуй үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 42,255,445.00 (дөчин хоёр сая хоёр зуун тавин таван мянга дөрвөн зуун дөчин таван) төгрөгийн балансын үнэ, үлдэх өртөг бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006637
32-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



Гаалийн ерөнхий газрын харьяа Инженер техник,
аж ахуй үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй Хил хамгаалах ерөнхий газарт балансаас
балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хууримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Эрэлч нохойн цогцолборын гадна төмөр бетон хашаа 104ш, аяга 106ш	2009/12/30	42,255,445.00	0	42,255,445.00
	Нийт дүн		42,255,445.00 (дөчин хоёр сая хоёр зуун тавин таван мянга дөрвөн зуун дөчин таван)	0	42,255,445.00 (дөчин хоёр сая хоёр зуун тавин таван мянга дөрвөн зуун дөчин таван)